



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 08 сарын 26 өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот

Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр
гадаадад сургах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Сэмжидийн Гарьдийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бонн хотын их сургуульд эрх зүйн чиглэлээр 2 жилийн хугацаатайгаар Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2.Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар/М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР